

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/68/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Б.Дагвасүрэн

Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn

Аудитор П.Ганцолмон

Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

ИХ-УУЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ЭНХЖАРГАЛ-д

№ 2022.07.24 № 1302/246
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

012025271

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

Хүчир
Д.Бат-Ундраа

Хүчир
Хүчир
2022.02.24

Хүчир

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	195,911,984.08	242,483,455.53
35	БАРАА МАТЕРИАЛ	195,911,984.08	242,483,455.53
351	Түүхий эд материал	116,681,843.74	135,059,053.74
35110	Тусгай зориулалттай материал	116,122,343.74	134,816,053.74
35130	Эм боох материал	559,500.00	243,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	2,565,350.00
354	Хангамжийн материал	79,230,140.34	104,859,051.79
35410	Бичиг хэргийн материал	2,854,095.00	2,553,595.00
35420	Аж ахуйн материал	50,502,298.74	65,581,824.79
35440	Түлш, шатах тослох материал	9,306,010.00	28,125,010.00
35460	Хүнсний материал	11,053,936.60	3,084,822.00
35470	Бусад хангамжийн материал	5,513,800.00	5,513,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,407,930,096.02	1,375,261,018.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,407,930,096.02	1,375,261,018.93
392	Биет хөрөнгө	1,289,980,721.02	1,257,724,143.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,226,676,899.83	1,221,664,099.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(313,384,073.27)	(361,966,609.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,500,000.00	13,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,142,857.04)	(6,428,571.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	361,942,431.40	307,362,216.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	(305,645,679.73)	(233,205,230.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	238,903,205.33	278,494,503.21
39208	Хуримтлагдсан элэгдэл	(120,112,375.09)	(142,180,516.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	174,607,161.44	174,607,161.44
39215	Хуримтлагдсан элэгдэл	(66,620,471.61)	(78,193,436.17)
39217	Ном	76,256,479.76	84,070,527.76
393	Биет бус хөрөнгө	117,949,375.00	117,536,875.00
39301	Програм хангамж	2,020,000.00	2,020,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(610,625.00)	(1,023,125.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	116,540,000.00	116,540,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I-II	1,603,842,080.10	1,617,744,474.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,603,842,080.10	1,617,744,474.46
51	Засгийн газрын хувь оролцоо	1,603,842,080.10	1,617,744,474.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,524,669,621.60	1,524,669,621.60
51101	Өмч: - төрийн	1,524,669,621.60	1,524,669,621.60
512	Хуримтлагдсан үр дүн	(518,225,067.89)	(500,661,644.53)
51210	Өмнөх үеийн үр дүн	(518,225,067.89)	(514,564,038.89)
51220	Тайлант үеийн үр дүн	-	13,902,394.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	597,397,526.39	593,736,497.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	1,603,842,080.10	1,617,744,474.46

2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (D)	1,126,524,651.94	1,980,531,442.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104,661,401.94	97,985,158.88
120	Нийтлэг татварын бус орлого	104,661,401.94	97,985,158.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	104,661,401.94	79,147,195.88
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	776,300.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	103,885,101.94	-
13	ГУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,021,863,250.00	1,882,546,283.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	996,122,050.00	1,734,315,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	996,122,050.00	1,734,315,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	63,347,583.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	63,347,583.82
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,741,200.00	84,882,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,741,200.00	84,882,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,181,405,770.72	1,958,914,762.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,181,405,770.72	1,958,914,762.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,169,620,020.72	1,846,178,638.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшилт	817,705,577.00	1,415,156,694.00
210101	Үндсэн цалин	630,434,458.00	906,442,462.00
210102	Нэмэгдэл	133,936,036.00	403,860,181.00
210104	Урамшуулал	53,335,083.00	104,854,051.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,025,565.00	182,173,206.00
210201	Тэтгэврийн даатгал	70,832,877.00	126,613,160.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,341,375.00	14,531,639.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,595,820.00	11,447,239.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,568,681.00	2,689,194.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,686,812.00	26,891,974.00
2103	Байр ашиг, лалттай холбоотой тогтмол зардал	49,455,478.00	62,302,709.00
210301	Гэрэл, цахилгаан	3,034,407.00	15,709,029.00
210302	Түлш, халаалт	46,421,071.00	46,478,080.00
210303	Цэвэр, бохир ус	-	115,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,456,020.00	21,725,222.77
210401	Бичиг хэрэг	2,962,450.00	9,055,341.82
210402	Тээвэр, шатахуун	1,361,820.00	3,519,604.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	279,000.00	360,000.00
210404	Ном, хэвлэл	-	399,000.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	852,750.00	8,391,276.95
2105	Нормативт зардал	5,127,000.00	31,617,369.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	204,000.00	1,316,500.00
210502	Хоол, хүнс	4,923,000.00	30,300,869.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,450,980.00
210604	Урсгал засвар	-	1,450,980.00

Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	396,000.00	3,937,600.00
210702	Дотоод албан томилолт	396,000.00	3,937,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,036,000.00	2,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	886,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	187,418,380.72	125,814,857.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,518,640.00	19,362,870.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	181,899,740.72	106,451,987.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,785,750.00	112,736,124.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,785,750.00	111,356,572.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,055,200.00	60,122,210.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	50,734,362.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс	5,360,550.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	370,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,379,552.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,379,552.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(54,881,118.78)	21,616,680.31
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	7,714,285.95
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	7,714,285.95
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(7,714,285.95)
5	НИЙГ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(54,881,118.78)	13,902,394.36

2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,524,669,621.60	597,397,526.39	(533,742,310.30)	1,588,324,837.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,524,669,621.60	597,397,526.39	(533,742,310.30)	1,588,324,837.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	15,517,242.41	15,517,242.41
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,524,669,621.60	597,397,526.39	(518,225,067.89)	1,603,842,080.10
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,524,669,621.60	597,397,526.39	(518,225,067.89)	1,603,842,080.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,661,029.00	3,661,029.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,524,669,621.60	597,397,526.39	(514,564,038.89)	1,607,503,109.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(3,661,029.00)	-	(3,661,029.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	13,902,394.36	13,902,394.36
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,524,669,621.60	593,736,497.39	(500,661,644.53)	1,617,744,474.46

2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,748,602,850.00	1,882,546,283.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,884,700.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,884,700.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,884,700.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,884,700.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,746,718,150.00	1,882,546,283.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,678,930,650.00	1,734,315,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,678,930,650.00	1,734,315,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	63,347,583.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	63,347,583.82
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,787,500.00	84,882,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	67,787,500.00	84,882,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,744,672,850.00	1,880,196,283.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,744,672,850.00	1,880,196,283.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,670,780,426.00	1,764,894,809.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,364,369,909.00	1,415,156,694.00
210101	Үндсэн цалин	1,052,844,484.00	906,442,462.00
210102	Нэмэгдэл	240,624,082.00	403,860,181.00
210104	Урамшуулал	70,901,343.00	104,854,051.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,328,067.00	182,173,206.00
210201	Тэтгэврийн даатгал	118,801,883.00	126,613,160.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,974,470.00	14,531,639.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,028,377.00	11,447,239.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,603,767.00	2,689,194.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,919,570.00	26,891,974.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,287,500.00	83,380,629.00
210301	Гэрэл, цахилгаан	7,881,383.00	15,709,029.00
210302	Тулш, халаалт	57,266,117.00	65,566,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,140,000.00	2,105,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,907,550.00	23,764,975.82
210401	Бичиг хэрэг	5,865,400.00	8,714,841.82
210402	Тээвэр, шатахуун	5,970,430.00	3,250,684.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	803,650.00	360,000.00
210404	Ном, хэвлэл	-	399,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	287,650.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,980,420.00	11,040,450.00
2105	Нормативт зардал	24,588,300.00	28,000,255.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,400,000.00	1,000,000.00
210502	Хоол, хүнс	18,354,100.00	22,331,755.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,834,200.00	4,668,500.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,450,980.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,450,980.00
2107	Томилолт, зочны зардал	5,907,700.00	3,937,600.00
210702	Дотоод албан томилолт	5,907,700.00	3,937,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,114,400.00	2,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,964,400.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,777,000.00	25,030,470.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,777,000.00	25,030,470.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,892,424.00	115,301,474.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,500,450.00	113,921,922.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,639,900.00	62,687,560.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	50,734,362.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,360,550.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,391,974.00	1,379,552.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,391,974.00	1,379,552.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,930,000.00	2,350,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,930,000.00	2,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,930,000.00	2,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,930,000.00	2,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,930,000.00	2,350,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,930,000.00)	(2,350,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдний засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,825,651,700.00	1,818,509,148.00	7,142,552.00	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,825,651,700.00	1,818,509,148.00	7,142,552.00	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,762,594,400.00	1,755,453,588.00	7,140,812.00	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,393,728,900.00	1,412,842,744.00	(19,113,844.00)	101%
210101	Үндсэн цалин	937,460,800.00	904,128,512.00	33,332,288.00	96%
210102	Нэмэгдэл	372,332,600.00	403,860,181.00	(31,527,581.00)	108%
210104	Урамшуулал	83,935,500.00	104,854,051.00	(20,918,551.00)	125%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,153,400.00	184,487,156.00	3,666,244.00	98%
210201	Тэтгэврийн даатгал	132,404,300.00	126,924,121.00	5,480,179.00	96%
210202	Тэтгэмжийн даатгал	13,937,300.00	15,347,935.00	(1,410,635.00)	110%
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,149,900.00	11,257,400.00	(107,500.00)	101%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,787,400.00	2,814,300.00	(26,900.00)	101%
210205	Эрүүл мэндийн даатгал	27,874,500.00	28,143,400.00	(268,900.00)	101%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,382,800.00	83,380,629.00	2,171.00	100%
210301	Гэрэл, цахилгаан	5,449,400.00	15,709,029.00	(10,259,629.00)	288%
210302	Түлш, халаалт	75,600,000.00	65,566,000.00	10,034,000.00	87%
210303	Цэвэр, бохир ус	2,333,400.00	2,105,600.00	227,800.00	90%
2104	Хягамж, бараа материалын зардал	20,276,100.00	22,746,200.00	(2,470,100.00)	112%
210401	Бичиг хэрэг	4,577,000.00	6,996,066.00	(2,419,066.00)	153%
210402	Тээвэр, шатахуун	5,470,600.00	3,250,684.00	2,219,916.00	59%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	360,000.00	440,000.00	45%
210404	Ном, хэвлэл	6,865,400.00	1,099,000.00	5,766,400.00	16%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,563,100.00	11,040,450.00	(8,477,350.00)	431%
2105	Нормативт зардал	50,668,500.00	28,132,255.00	22,536,245.00	56%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00	-	100%
210502	Хоол, хүнс	45,000,000.00	22,463,755.00	22,536,245.00	50%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,668,500.00	4,668,500.00	-	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,450,980.00	49,020.00	97%
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,450,980.00	49,020.00	97%
2107	Томиллолт, зочны зардал	6,407,700.00	3,937,600.00	2,470,100.00	61%
210702	Дотоод албан томилолт	6,407,700.00	3,937,600.00	2,470,100.00	61%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00	2,000,000.00	-	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэгдэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,477,000.00	16,476,024.00	976.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,477,000.00	16,476,024.00	976.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,057,300.00	63,055,560.00	1,740.00	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,057,300.00	63,055,560.00	1,740.00	100%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,557,300.00	62,555,560.00	1,740.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,825,651,700.00	1,819,198,700.00	6,453,000.00	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,825,651,700.00	1,734,834,700.00	90,817,000.00	95%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,825,651,700.00	1,734,834,700.00	90,817,000.00	95%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	84,364,000.00	(84,364,000.00)	
132001	Орон нутгийн төсвөөс	-	84,364,000.00	(84,364,000.00)	

2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,734,362.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,734,362.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,734,362.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,734,362.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,734,362.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургуультай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль нь Суралцагч бүрийг боловсролд тэгш боломжоор хангах, хүүхэд бүрийн онцлог ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сурах, хөгжих үйлийг дэмжиж, хамтран суралцах соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Засаг даргын дэргэдэх төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль нь Дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Өмнө нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж,

нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг дахин тогтоож АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 3,000.0 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1,980,5231.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 19,000.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 12,800.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	-	-	-
Бараа	195,911.9	242,483.4	46,571.5
Үндсэн хөрөнгө	1,407,930.1	1,375,261.0	-32,669.1
Нийт хөрөнгө	1,603,842.0	1,617,744.4	13,902.4
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,603,842.0	1,617,744.4	13,902.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө	1,603,842.0	1,617,744.4	13,902.4

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 46,571.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал, бэлэн бүтээгдэхүүн, аж ахуйн материал, түлш шатах тослох материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 186,332.9 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 18,837.9 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэн, 158,599.4 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 32,669.0 мянган төгрөгөөр буурсан нь барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн данснаас хөрөнгийн хасалт хийгдсэнээс үүссэн. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 2,350.0 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 79,147.1 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэн машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, барилга байгууламж зэрэг нийт 122,970.5 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,902.4 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,825,65.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,818,509.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 84,882.8 мянган төгрөгийн, улсын төсвөөс 1,734,315.9 мянган төгрөг нийт 1,819,198.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,815,469.1 мянган төгрөгийг зарцуулж, 1,379.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 50,734.3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого орж тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжинд 50,734.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын код: ЗАА-2022/68/СТА-ТШЗ

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 5 байна.

Хугацаа хоцроосон 5 мэдээлэл нь 11-р сарын Төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингаас бусад таван сая төгрөгөөс доош үнийн дүнтэй орлого, зарлагын мөнгөн гүйлгээ байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7, Сангийн сайдын 2014 оны 55 тушаалын Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж ажиллах. Тушаал төлөвлөхдөө холбогдох хуулийн заалтыг хууль тогтоомжинд нийцүүлэн гаргах

4. Аудитын илрүүлэлт

Тус байгууллага нь тайлант хугацаанд 221,667.3 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн боловч татварын сайт дахь и баримтын бүртгэлээр 349,570.4 мянган төгрөг тайлагнагдаж 127,903.1 мянган төгрөгийн гүйлгээг илүү бүртгэж тайланд тусгасан, багш Б.Тогтохсүрэнд өндөр насны тэтгэвэрт гарсантай холбогдуулан 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгосон 841.7 мянган төгрөгт зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага: өгөгдөөгүй

4.4 Зөвлөмж

Захирлын тушаалын үндэслэлгүй буруу тодорхойлж олгосон 841.7 мянган төгрөгийн тэтгэмжинд 1, и баримттай холбоотой 127,903.1 мянган төгрөгийн гүйлгээнд нийт 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин хөлсний данстай холбоотой асуудал

- ✓ **Илрүүлэлт:** Байгууллагын захирлын 2021 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/21 тоот тушаалын заалт нь тэтгэмж олгох хуульд нийцэхгүй, өндөр насны тэтгэвэрт гарсантай холбогдуулан 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 841.7 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.
- ✓ **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” тогтоох; гэсэн заалтыг зөрчсөн гэж үзлээ.

2.Татварын данстай холбоотой асуудал

- ✓ Илрүүлэлт: Тус байгууллага нь тайлант хугацаанд 221,667.3 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн боловч татварын сайт дахь ибаримтын бүртгэлээр 349,570.4 мянган төгрөг тайлагнагдаж 127,903.1 мянган төгрөгийн гүйлгээг илүү бүртгэж тайланд тусгасан байна.
- ✓ Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Их-Уул сумын Ерөнхий боловсролын	2	128.7	-	-	-	-	0	-	2	128.7